

тэдний хэрэглэдэг үг хэллэг, зан үйл олон нийтэд хүрэх хандлагатай,

- Эдгээрийг бичиг зохиолын хэлэнд хэрэглэх шаардлагагүй, тодорхой бүлгийн дунд хэрэглэдэг, тогтмол утгаа хадгалах үүрэггүй, хязгаарлагдмар шинжтэй, ялтан, хоригдогсдын харилцааны өвөрмөц хэрэгсэл гэдгийг илтгэж байна.

Ялтан, хоригдогч нарын харилцааны түвшин тэдний өөрсдийн үнэлгээгээр төдийгүй тэдэнтэй тогтмол харилцдаг албан хаагчдын үнэлгээгээр соёлын түвшин доогуур гэж үнэлэгдэж байгаа тул цаашид соёлтой харилцаанд сургах, тухайн чиглэлийн сургалтыг тогтмол зохион байгуулах, нөлөөллийн ажил явуулах, тэдний харилцаанд хэрэглэгдэх этгээд үг хэллэг нь бие даасан харилцааны өвөрмөц хэрэгсэл болохын хувьд түүний сөрөг үр дагаварын тооцон урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, улмаар ялтан, хоригдогсдод үндэсний уламжлалт харилцаа, өв соёлоос суралцах, соёлтой харилцааг эзэмшүүлэх чиглэлээр ном, гарын авлага боловсруулах саналыг гаргаж байгаа бөгөөд эдгээр нь зөвхөн онол судлалын төдийгүй хэрэглээний чухал ач холбогдолтой арга хэмжээ мөн гэж үзэж байна.



Г.БАТТУЛГА

*Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Аюулгүй
байдлын тэнхимийн
ахлах багш, хошууч*

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Хорих ял нь Монгол Улсын эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд Шүүхийн шийтгэх тогтоолоор ногдуулдаг шүүхийн практикт өргөн хэрэглэгддэг ял бөгөөд "үндсэн агууллага нь ялтныг олон нийтээс тусгаарлаж, харуул хамгаалалт, хяналт бүхий нөхцөлд хорих тусгай байгууллагад байлгахад"¹⁴⁷ оршдог. Хорих ялыг иргэдийн гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ¹⁴⁸.

Хорих байгууллага нь хорих ялын зорилгыг хэрэгжүүлэх үүднээс ялтныг гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх, тэднийг нийгэмшүүлэх ажлыг оновчтой, үр нөлөөтэй зохион байгуулах үндсэн үүргийг нийгмийн өмнө хүлээдэг. Гэвч ШШГЕГ-ын нийгэм, сэтгэл судлалын хэлтсээс гаргасан хорих ангиудын хэмжээнд 2010-2014 онд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн

¹⁴⁷ Нарангэрэл.С Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007. 517 дах тал

¹⁴⁸ Мөн тэнд 658 дах тал

судалгаанаас харахад 2010 онд ялтны зүгээс үйлдсэн гэмт хэргийг тоо 2014 онд 2 дахин өссөн үзүүлэлт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хорих байгууллага тун хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь харагдана¹⁴⁹. Тэгвэл хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтны зүгээс үйлдэгдэж буй гэмт хэрэг буюу "Пенитенциар"¹⁵⁰ гэмт хэргийг хэрхэн бууруулах вэ? Түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? гэх мэт асуултууд урган гарна. Энэхүү асуудлын хүрээнд хорих байгууллагад хоригдож буй ялтны дотроос гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үр ашигтай арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар авч үзэхийн өмнө "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" гэсэн ойлголтыг онолын болон хууль эрх зүйн түвшинд тодорхойлох нь зүйтэй юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэдгийг "гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж

байгаа цогцолбор арга хэмжээ"¹⁵¹ гэж тодорхойлсон байна.

Харин гадны болон манай орны судлаачдын онолын тодорхойлсноос үзвэл өөр хоорондоо төдийлөн зөрүүгүй болох нь харагдана. Тухайлбал Канадын эрдэмтэн, криминологич Стейфан Шнейдер "аливаа гэмт үйлдэл гарахаас өмнө буюу үйлдэгдэхээс өмнө тухайн нөхцөл байдалд нь тохируулан урьдчилан хэрэгжүүлж буй идэвхтэй үйл ажиллагаа /proactive action/ гэмт үзэгдлийг гаргахгүй байх, эрсдлийг багасгахаар авч буй олон талт арга хэмжээ"¹⁵² гэсэн бол доктор, профессор Н.Жанцан "Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь уг үзэгдэлд нөлөөлөх хүчин зүйлсийн хүч, үйлчлэлийг сулруулах аажмаар арилгах...бүхэл бүтэн шаталсан систем бөгөөд түүнийг хэрэгжүүлэх ажиллагааг нэгж салбар бүр дээр ялгамжтай зохион байгуулана"¹⁵³ гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн арга зүй ойлголтыг тодорхойлсон байна.

Дээрхээс харахад "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн тодорхойлолт, гадны болон манай эрдэмтэдийн гаргаж буй онолын тодорхойлолттой нийцэж байна гэж үзэж болно. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг "зөвхөн тодорхой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хууль сахиулах байгууллагуудаас зохиох криминологийн тусгай арга хэмжээгээр

¹⁴⁹ ШШГЕГ-н Нийгэм, сэтгэл судлалын хэлтэсээс гаргасан хорих ангиудын хэмжээнд 2010-2014 онд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн судалгаа. 2014 он.

¹⁵⁰ "Пенитенциарное преступление" "Penitentiary crime" гэдэг нь хорих ял эдлүүлэх явцад үйлдэгддэг гэмт хэргийн олон улсын нэршил юм. Манай оронд ч "Пенитенциар криминологи" "Пенитенциар гэмт явдал, гэмт хэрэг" гэсэн нэр томъёо хэрэглэгдэх болжээ.

¹⁵¹ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. УБ. 1997. 3-р зүйл

¹⁵² S.Schneider. Crime prevention theory & practice. CRC Press. 2010. p 4

¹⁵³ Н.Жанцан ., Криминологи. УБ.2000. 64 дэх тал

хязгаарлаж болохгүй¹⁵⁴ юм. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах талаар явуулж буй нийтлэг, өргөн цар хүрээтэй арга хэмжээ гэж авч үзэх ёстой.

Нийгэмд гарч буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь өргөн хүрээтэй нэгдсэн ойлголт, арга хэмжээг ойлгох бол хорих байгууллагад үйлдэгддэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь "пенитенциар" орчинд буюу хорих байгууллагад явагддагаараа онцлог юм. Пенитенциар орчинд явагдаж буй урьдчилан сэргийлэх ажиллагаа нь криминологийн шинжлэх ухааны ололтод тулгуулан явуулдаг практик ажиллагааны, төрөл, хэлбэр, хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн бодит шийдлүүд, арга ажиллагааны иж-бүрдэл байдаг.

Гэвч нэн тэргүүнд хорих байгууллагад гарч буй гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлаж тогтоох нь чухал. Өөрөөр хэлбэл хорих байгууллагад гарч буй гэмт хэрэг, түүний шалтгааны нөхцлийн талаар тодорхой судалгааг бодитой, криминологийн шинжлэх ухааны үндэслэлтэй хийх явдал юм. Ингэснээр гэмт хэрэгтэй хийх тэмцлийг оновчтой тодорхойлж хүч хэрэгслээ зөв хувиарлах, хорих байгууллагад гарч буй сөрөг үзэгдлийг хэмжих хэмжүүрийг бий болгох, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны явц, үр дүнг тодорхойлох боломжыг бүрдүүлнэ.

Хорих байгууллагад үйлдэгддэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар, ялгамжтай,

төрөлжүүлэн явуулах, уг ажиллагаанд оролцогч субъектуудын үүргийг тодорхой оновчтой болгох; тэдгээрийн уялдаа холбоог оновчтой зохион байгуулах нь чухал юм. Ялангуяа хорих ангийн харуул хамгаалалтын албан хаагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч болон бусад албадын хоорондын ажлын уялдаа холбоо муу байгаа нь хорих байгууллагад гэмт хэрэг, зөчил гарах нэгэн нөхцөл болоод зогсохгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж буйг үгүйсгэх аргагүй билээ.

Оросын холбооны улсын криминологид хорих байгууллагад гарч буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг дараах гурван түвшинд¹⁵⁵ хуваан авч үзжээ. Үүнд:

1. Ерөнхий буюу нийтлээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Үүнд хорих байгууллагын зүгээс хорих ял эдлэгсдийн бие авч явах байдал, ялтан болон албан тушаалтнуудтай хэрхэн харьцах, тэднийг хорих ангийн дотоод дүрэм журамд захирагдаж, зөрчил гаргах гэх мэт харш үйлдэл хийхгүй байхад чиглэсэн хорих байгууллагаас авч буй цогц үйл ажиллагаа юм. Тухайлбал гэмт зан төлөв төдийлөн тогтож төлөвшөөгүй, ёс суртахууны хүрээнд алдаа гарган тэр нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн зан байдлын гажуудлыг засах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ үүнд багтана. Мөн бусдын нөлөөнд автагдаж гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд эерэг зан байдлыг төлөвшүүлэх, тэдний гэмт санаа бодлыг эерэг зүйлд хандуулж байхад чиглэгдсэн арга хэмжээг

¹⁵⁴ Н.Жанцан дурдсан зохионын 65 дах тал

¹⁵⁵ Пенитенциарная криминология. Рязань. 2009 г. 183 ст

багтаасан олон талт ажиллагааг мөн хамаарна.

2. Шууд урьдчилан сэргийлэлт

Энэ нь тодорхой ялтнуудад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ бөгөөд уг арга хэмжээнд хамрагдаж байгаа ялтнууд давтан гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүд байна. Эдгээр болцошгүй гэмт хэрэгтнүүдийг дахин гэмт хэрэг өдүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд тэдэнтэй тодорхой төлөвлөгөө боловсруулан ажиллана. Ялантай ажиллах явцдаа хорих байгууллагын ажилтнууд харилцааны ямар нэг алдаа дутагдал гаргалгүйгээр тэдэнтэй хүнлэг, хүндэтгэлтэй харьцахыг анхаарах ёстой. Мөн тухайн ялтны үйлдсэн гэмт хэрэг, зан төлөв болон анх удаа, давтан, удаа дараа гэмт хэрэг үйлдсэн эсэхээс шалтгаалан тэдэнд тохирсон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна. Тухайлбал тодорхой бүлэг этгээдүүдийг судлаж гэмт хэрэг үйлдэх болсон учир шалтгаануудыг тодруулах, тэдний дотороос хэн нь дахин гэм хэрэг үйлдэж болзошгүй этгээд болохыг нарийвчлан судлан, тогтоосон байх. Өөрөөр хэлбэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад сэтгэл зүйн шинжлэх ухааныг мэдлэгийг өргөн хэрэглэх шаардрагатай болдог.

3. Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэлт

Энэ нь нэг этгээдрүү чиглэсэн нэг бүрчилсэн арга хэмжээ бөгөөд тухайн ялтныг тусгайлан авч үзэж зан байдлын онцлог, шинж чанар, түвшин буюу мэргэжил, боловсрол, нийгмийн гарал, яс үндэс шашин шүтлэг гэх мэт тухайн этгээдийг хэн бэ гэдгийг

нарийвчлан тодорхойлж түүнд тулгуурлан явуулах урьдчилан сэргийлэх ажиллагааг ойлгоно. Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэлт нь гэм хэрэг гарах, үйлдэх болсон тодорхой нэг шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэгдэнэ. Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэлтийн үндсэн нь а) Ялтныг хорих байгууллагад хүлээн авснаас хойш нарийн судлах үүний үндсэн дээр давтан гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийг илрүүлэх, тодорхойлох б) Гэмт хэрэг үйлдэх магадлалтай этгээдийг тодорхойлсны үндсэн дээр ямар аргаар урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах талаар төлөвлөлт гаргах. в) Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээний хүрэх үр дүнг тодорхойлох. Тухайлбал шинээр ирж буй ялтнуудын хорих байгууллага хүлээн авч хорих байгууллагын үйл ажиллагаанд дасгахаас эхлэн тухайн ялантай тогтмол, тасралтгүй ажилласнаар түүнийг гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх бодит үр дүнд хүрэх боломжтой гэж үздэг. г) Гэмт хэрэг үйлдэх үр үндэс болсон бодит шалтгааныг тодорхойлж, мөн чанарыг таньж мэдсэнээр гэмт үйлдлийг зогсоох, таслах, тухайн ялтны онцлог, үйлдэж болзошгүй гэмт үйлдэлд тохирсон урьдчилан сэргийлэх ажиллагаа, арга замыг зөв оновчтой зохион байгуулахад чухал ач холбогдолтой.

Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд хамгийн гол нь “дээр дурдсан арга хэмжээ хоорондоо нягт

уялдаа холбоотой тасралтгүй явагдаж байх ёстой¹⁵⁶ билээ.

Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дээрх түвшингийн арга хэмжээнүүдийг ямар субъект хэрхэн хэрэгжүүлэх, ямар зохион байгуулалттай ажиллах талаар манай орны хорих байгууллагын хэмжээнд нэгдсэн ойлголт тун хомс энэ талаар хийсэн дорвитой судалгаа ч алга байлаа. Түүнчлэн “хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулинд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад гардаг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх”¹⁵⁷, урьдчилан сэргийлэх талаар нарийвчлан тусгасан заалт байхгүй байна. Тухайлбал субъектын хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хорих байгууллагын хэмжээнд уялдуулан зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангадаг, пенитенциар гэмт хэргийн шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулдаг судалгааны төвийг багтаасан бүтэцийг байгуулах шаардлага бий болжээ.

Өргөн утгаараа пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд хорих байгууллагын субъектууд болох гүйцэтгэх ажил харуул хамгаалалтын алба, нийгмийн ажлын алба, эмнэлэг болон үйлдвэрлэл аж ахуй, санхүү зэрэг бүх бүтэц хамрагдаж пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу ажиллах шаардлагатай болдог.

Дээрх үе шаттай уялдуулан пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хорих байгууллагад зохион байгуулах субъектүүдийн бүтэцийг чиг үүргийнх нь хувьд дараах байдлаар ангилан авч үзэж болно.

❖ *Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ердийн буюу мэргэшээгүй субъектууд.* Үүнд хорих байгууллагын аж ахуйн алба буюу хөдөлмөр зохион байгуулалт, ахуй хангалтын алба, хорих байгууллагын ажилтнаас гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 124 дүгээр зүйлд зааснаар шашны, буяны болон бусад байгууллагуудыг хамааруулна. Эдгээр байгууллагуудын гүйцэтгэх үүрэг нь ялтныг хөдөлмөр эрхлүүлэх, тэднийг ажлын байраар хангах, шашин шүтлэгээр дамжуулан энэрэнгүй үзлийг төлөвшүүлэх, албан болон албан бус боловсрол олгох замаар ялтны дундаас гэмт хэрэг гаргахаас урьдчилан сэргийлэх ажилд тодорхой хувь нэмэр оруулж, оролцох зэрэг болно.

➤ *Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэсэгчлэн мэргэшсэн субъектууд.* Үүнд хорих байгууллагын үндсэн бүтцэд байдаг субъектүүд хамаарагдах бөгөөд эдгээр нь өөрсдийн үндсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа боловсруулан ажиллана. Тухайлбал хүмүүжлийн ажлын нэгж хорих байгууллагад байх шаардлагатай бөгөөд хүмүүжил, зан байдал, ёс суртахууны доголдолтой гэмт хэрэг зөрчил гаргаж болзошгүй ялтнуудад тусгайлан болон ганцаарчлан хүмүүжлийн ажил зохион байгуулах хэрэгцээ бий болдог. Мөн

¹⁵⁶ Пенитенциарная криминология. Рязань. 2009 г. 184 ст

¹⁵⁷ Б.Алтангэрэл., *Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүнийг судлах нь. Хууль сахиулахуй сэтгүүл.* 2014.№2 (2). УБ. 40 дэх тал.

хорих байгууллагын сэтгэл судлалын албаны ажилтнууд анхаарал татаж буй ялтнуудын, гэмт хэрэг үйлдэж болцошгүй эрсдэл бүхий бүлэгт сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэн хяналт тавих ажиллагаа явуулна. Хорих байгууллагад гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэхэд хорих байгууллагын сэтгэл зүйч, эмч ялтнуудыг эмнэлгийн үзлэгт хамруулж байх нь чухал ач холбогдолтой байдаг. Өөрөөр хэлбэл сэтгэхүйн өөрчлөлттэй ялтнуудын судалгааг гарган эсрэг үйлдэл хийх, түрэмгий зан авир, өөртөө санаатай гэмтэл учруулах болон мансуурах, согтуурах донтой зэрэг ялтнуудын талаар хорих байгууллагын харуул хамгаалалт, гүйцэтгэх албанд мэдэгдэх зэрэг үйл ажиллагааг явуулна.

➤ *Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэшсэн тугай субъектууд.* Хорих байгууллагад үйлдэгддэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг ерөнхийд нь зохицуулж гол чиг үүргийг хэрэгжүүлдэг үндсэн байгууллага нь аюулгүй байдлын хэлтэс /алба/ байдаг. Энэхүү алба нь ОХУ болон гадны бусад орнуудын хорих байгууллагын бүтэцийн салшгүй нэг хэсэг нь байдаг. Манай орны хувьд хорих байгууллагын аюулгүй байдлыг шинэ түвшинд гаргах үүднээс ШШГЕГ-н Аюулгүй байдал, тусгай ажиллагааны газар шинээр байгуулагдаад байгаа нь пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахад чухал ач холбогдолтой субъект гэж үзэж байна. Ялтны дунд байдаг албан бус бүлэглэлүүдийн харилцаа, ялтны доторх уур амьсгал, нууц далд аргаар үйлдэгддэг хорих ангийн дэглэм журам зөрчиж буй аливаа үйлдлийг цаг

алдалгүй илрүүлж, таслан зогсоож, гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг чухал субъект нь хорих байгууллагын гүйцэтгэх алба юм. Гүйцэтгэх ажлыг үр нөлөөтэй явуулснаар зөрчил гаргагч ялтнуудыг гэм буруугаа сайн дураар хүлээх, төлөвлөж буй гэмт хэрэг зөрчлөөс татгалзах, илрээгүй гэмт хэрэг, зөрчил болон түүнийг үйлдсэн этгээдийг олж, илрүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг. Хорих байгууллагын харуул хамгаалалтын алба нь хорих ангийн өдөр тутмын цагийн хуваарь, дэглэм журам, хөдөлгөөнд хяналт тавин, үзлэг нэгжлэг хийх хамгаалалтын техник хэрэгслийн тусламжтай хорих ангид орж гарч буй хөдөлгөөн, хамгаалалтын бүс, хашааны бүрэн бүтэн байдлыг ханган ажилладаг. Мөн оргож болзошгүй ялтнуудад тусгай хяналт тавин урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний дагуу биечлэн болон техник хэрэгслийн туламжтайгаар хяналт тавин ажиллана.

Мөн хорих ял эдлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүрэг бүхий прокурорын байгууллага нь хэдийгээр хорих байгууллагын бүтэцэд орохгүй ч пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бие даасан субъект болдог¹⁵⁸. Өөрөөр хэлбэл хууль тогтоожийн хэрэгжилтэнд хяналт тавьснаар түүнийг зөрчигчид хариуцлага тооцон хууль тогтоомжийг дахин зөрчих ялдлыг таслан зогсоож, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг субъект юм.

¹⁵⁸ Пенитенциарная криминология. Рязань. 2009 г. 190 ст